**ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН**
**ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 25 өдөр | Дугаар А/73 | Улаанбаатар хот

Зөвлөмжийн мөрөөр авах
арга хэмжээ

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дээд шатны байгууллага буюу Эрүүл мэндийн яамнаас Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/127 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нэр бүхий ажилтны гаргасан гомдлын дагуу Геронтологийн үндэсний төвийн хүний нөөц, худалдан авах ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэл, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулсан зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж Эрүүл мэндийн яаманд 2025 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн дотор тайланг хүргүүлэх, Удирдлагын зөвлөлд танилцуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэг (М.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний Чанар аюулгүй байдлын албаны дарга (Г.Энхсүрэн)-д даалгасугай.

ЗАХИРАЛ Р.ХИШИГЖАРГАЛ

ОТУ0816
5026814 9023110500

Геронтологийн үндэсний төвийн захирлын
2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
А/73 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН БАТАЛСАН УДИРДАМЖИЙН ДАГУУ ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ, ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Геронтологийн үндэсний төвийн үйл ажиллагаанд үүссэн зөрчлийн арилгаж, хэвийн үйл ажиллагааг хангах

Хамрах хүрээ: Геронтологийн төвийн бүх ажилтнууд

Хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 24-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр хүртэлх

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|---|---|
| Зөвлөмж 1. Байгууллагын үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, мэргэжлийн хүний нөөцийн удирдлагыг сайжруулах; | | | | | | |
| 1 | Удирдлагын зөвлөлийн гишүүдийг манлайлал, ур чадвар, харилцаа, хандлагыг сайжруулах сургалтыг тасралтгүй зохион байгуулах | Сургалт хамрагдсан удирдах ажилтны тоо | 2025 онд Удирдлагын гишүүдээс 6 ажилтан сургалтад хамрагдсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | М.Энхбаяр Дэд захирал |
| 2 | Мэргэжлийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ авах | Зөвлөн туслах үйлчилгээ авсан тайлан | Мэргэжлийн хүний нөөцийн удирдлагын чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ авсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | М.Энхбаяр Дэд захирал |
| Зөвлөмж 2. Төрийн хэмнэлтийн тухай хууль, дагалдаж гарсан Засгийн газрын тогтоол, шийдвэрийг мөрдөж ажиллах; | | | | | | |
| 3 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан "анхан шатны баримт"-ыг бүрдүүлж | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | "Нарлаг хайст" ХХК-д автомашины сэлбэг хэрэгслийн төлбөр 3,500,000 төгрөгийн гүйлгээг санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэх | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Д.Гунгаажав Эдийн засагч | П.Байгалмаа Нярав П.Байгалмаа Д.Жагдал Жолооч |

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|---|---|
| | гүйлгээ хийх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтуудыг зөрчсөн зөрчлүүдийг арилгаж, цаашид хэрэгжүүлж ажиллах | | "Гүн Хабсу" ХХК-ийн хооронд байгуулсан 2024 оны 2024/02 дугаартай "Автомашины гараж түрээслэх гэрээ" хуурамч байж болзошгүй байгаа тул дахин шалгалт хийж төсвийн шууд захирагчид танилцуулах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Д.Гунгаажав Эдийн засагч | Д.Янжмаа Ахлах нягтлан бодогч П.Байгалмаа Нярав Д.Жагдал Жолооч |
| 4 | | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | "Гүн урлал мөнх" ХХК-ний захирал нар нь шинээр ашиглалтад орох эмнэлгийн барилгын 1 дүгээр давхрын дотор засал, тохижилт хийлгэхээр 2024/09/02 дугаартай, 8,000,000 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан байна. Энэхүү гэрээг байгуулахаас өмнө ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудаас авсан үнийн санал авах, зах зээлийн ханшнаас өндөр үнэтэй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Д.Гунгаажав Эдийн засагч | Д.Янжмаа Ахлах нягтлан бодогч П.Байгалмаа Нярав |
| 5 | | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | "Космос тек Монгол" ХХК-аас нийлүүлсэн 51,000,000 төгрөгийн үнэ бүхий цахилгаанаар өвдөлт намдаагчийн үнэний талаар холбогдох тайлбарыг авах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Д.Янжмаа Ахлах нягтлан бодогч | Д.Гунгаажав Эдийн засагч П.Байгалмаа Нярав |
| 6 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | Монгол улсын засгийн газрын 2019 оны 01сарын 09 ний өдрийн 6 тоот тогтоол "Төрийн албан хаагчид нөхөн төлбөр олгох журам" Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Д.Янжмаа Ахлах нягтлан бодогч | Д.Гунгаажав Эдийн засагч П.Байгалмаа Нярав Д.Жагдал |

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|---|---|
| | автомашин ашиглахыг хориглосон байна. | | Авто машины гаражийн түрээсийн үний судалгааг хийж гэрээ байгуулан төвийн 3 автомашинуудыг журмын дагуу дулаан зогсоолд байршуулж, өвөлжилтийн бэлэн байдал, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах | | | Жолооч |
| Зөвлөмж 3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж, өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж ашиглах; | | | | | | |
| 7 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-т заасан заалтыг хангаж ажиллах | Эд хөрөнгийн хүлээж авсан тайлан | ГУТ-ийн хөрөнгө болох эмнэлгийн зориулалттай 44 ширхэг орыг агуулахын эзэн гэх иргэн Манлай-Эрдэнэтэйтэй байгуулсан гэрээг дүгнэж агуулахын түрээсийн үнийн судалгаа хийж шалгарсан байгууллагатай гэрээ байгуулан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, эд хариуцагч хүлээж авах. | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | П.Байгалмаа Нярав | Д.Янжмаа Ахлах нягтлан бодогч<br><br>Д.Гунгаажав Эдийн засагч |
| 8 | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/414 дүгээр тушаалаар баталсан "Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам"-д заасны хороо нь эмийн сонголт, түгээлт хадгалалт, хэрэглээ, хүртээмжид хяналт тавих .....зорилготой. Мөн журмын 3.1.9 заалтыг хэрэгжүүлж ажиллах | Хяналт үнэлгээ хийсэн тайлан | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/414 дүгээр тушаалаар баталсан "Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллах, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны хяналт-үнэлгээг хийж төвийн удирдлагын зөвлөлд танилцуулах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Г.Энхсүрэн ЭМТҮЧАБАлба ны дарга | А.Байгалмаа ЭТҮАлбаны дарга |
| Зөвлөмж 4. Байгууллагын ажилтнуудын харилцаа хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх хууль тогтоомжийг судлуулан, мөрдөж, ажиллах; | | | | | | |
| 9 | Ажилтнуудын харилцаа | Зохион | 2025 онд төлөвлөгөө гаргаж, 2025 оны | 2025 оны | Р.Даваадорж | ЭМЁСХороо |

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|---|---|
| | хандлагыг төлөвшүүлэх, ёс зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөх хууль тогтоомжийг судлуулан, мөрдөж, ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх | байгуулсан арга хэмжээний тайлан | 01 дүгээр сард 1-2 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | 01 дүгээр сарын 24-ны өдөр | ЭМЁСХорооны дарга | |
| өвлөмж 5. Албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангах, хөдөлмөрийн харилцаанд дарамтаас рьдчилан сэргийлэх, таслан зогсооход онцгой анхаарч албан хаагчдын тогтвор суурьшлыг хангах; | | | | | | |
| 0 | Хүний нөөцийн сэтгэл ханамжийн судалгаа хийж, дүгнэлт зөвлөмжийг удирдлагын зөвлөлд танилцуулах | Судалгааны тайлан | 2024 онд сэтгэл ханамжийн судалгааны тайлан удирдлагын зөвлөлд танилцуулга хийж, арга хэмжээ төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлсэн байна. | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | Г.Энхсүрэн ЭМТҮЧАБАл баны дарга |
| 1 | Ажлын байрны Сүүлийн 3 жилийн шилжилт хөдөлгөөний шалтгааныг нарийвчлан судалгаа хийж, удирдлагын зөвлөлд танилцуулах | Тайлан мэдээ | Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний тайланг сүүлийн 3 жилээр дэлгэрэнгүй гаргаж санал зөвлөмж боловсруулсан байна. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний судалгааг тухай бүрд нь авч хэвшүүлсэн байна. | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | М.Энхбаяр Дэд захирал |
| 12 | Хөлсөөр ажлуулах гэрээг үндсэн орон тоон дээр байгуулж ажлуулсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | - |
| 13 | Хөдөлмөрийн гэрээг томилогдох тушаал гарахаас өмнө байгуулсан зөрчил гарсан байна. | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | |
| 14 | Хөлсөөр ажиллах гэрээнд сар бүр ажилласан | Зөрчлийг арилгасан арга | Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах | 2025 оны 01 дүгээр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн | |

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|---|---|
| | хугацааны тайланг бичихээр заасан ч ажилчдын гэрээг дүгнэсэн акт үйлдээгүй, гэрээт ажилтны тайланг хавсаргаагүй, зөвхөн тойрох хуудсаар ажлыг хүлээлцсэн зөрчлийг арилгах | хэмжээ | | сарын 10-ны өдөр | менежер | |
| 15 | Хүний нөөцийн томилгооны тушаалын талаар гарсан зөрчлүүдийг арилгах | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | |
| | Төвийн захирлын 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/64 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Шинэ ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын хэрэгжилтийг хангах. | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | Зөрчлийг арилгаж, төвийн захиралд танилцуулах | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | |
| 16 | Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Боловсруулсан төлөвлөгөө | Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | Д.Янжмаа Ахлах нягтлан бодогч |
| Зөвлөмж 6. Хөдөлмөрийн дотоод журмыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн шинэчилж, нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулах | | | | | | |
| 17 | Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах | Боловсруулан батлуулсан журам | Хөдөлмөрийн дотоод журмыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээрт нийцүүлэн шинэчилж, нийт ажилтанд танилцуулж, | 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | М.Энхбаяр Дэд захирал |

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|---|---|
| | | | харагдахуйц газар байршуулсан байна. | | | |
| 18 | Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг хангаж ажиллах | Хэрэгжилтийн үнэлгээний тайлан | Хөдөлмөрийн дотоод журмын 3.3, 5.3, 9.17.6 дахь заалтуудыг хэрэгжүүлж, илтгэх хуудсаар төвийн захирал болон удирдлагын зөвлөлд танилцуулсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | М.Энхбаяр Дэд захирал |
| Зөвлөмж 7. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн шинэчлэх; | | | | | | |
| 19 | Ажлын байрны дутуу байгаа албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулж батлуулаалах | Боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо | 6 орон тооны албан тушаалын тодорхойлолт боловсруулж батлуулсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | |
| 20 | Бүх ажилчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах | Боловсруулсан албан тушаалын тодорхойлолтын тоо | 52 орон тооны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | Хуулийн зөвлөх |
| Зөвлөмж 8. Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах | | | | | | |
| 21 | Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартыг хэрэгжүүлж ажиллах | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, баримт бичгийн стандартыг зөрчсөн эсэхэд үнэлгээ хийж, холбогдох ажилтнуудыг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх | 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр | Ц.Байгалмаа Архив бичиг хэргийн эрхлэгч | Хуулийн зөвлөх |
| Зөвлөмж 9. Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй, шударга, ёс зүйтэй байдлыг хангах, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг шуурхай арилгах, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх | | | | | | |
| 22 | Төвийн цахим хуудасны "Хүний нөөцийн ил тод байдал-Нээлттэй ажлын байр" цонхонд сул орон тооны мэдээллийг үйл | Зөрчлийг арилгасан арга хэмжээ | Хүний нөөцийн ил тод байдал-Нээлттэй ажлын байр" цонхонд сул орон тооны байршуулж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж ажилласан байна. | 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер | Д.Янжмаа Ахлах нягтлан бодогч |

| № | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран ажиллах |
|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг сайжруулах, тасралтгүй байдлыг хангах | | | | | Сүлжээний инженер |
| 23 | Ажилтнуудын хариуцлагыг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах | Гарсан шийдвэрүүдийн тоо | Зөвлөмжийн дагуу холбогдох ажилтнуудыг удирдлагын зөвлөлийн хурлаар болон хамт олны хурлаар хэлэлцүүлж хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэсэн байна. | 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр | Ч.Өнөрцэцэг Хүний нөөцийн менежер<br>ОТУ0816<br>5026814 9023110500 | Р.Хишигжаргал Захирал<br><br>Хуулийн зөвлөх |

Геронтологийн үндэсний төвийн захирлын
2024 оны 12 дугаар сарын 25 ний өдрийн
А/73 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОТҮ0816
9023110500

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНААС БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛСАН ЗӨВЛӨМЖИЙН МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ АЖЛЫГ ХАРИУЦСАН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/127 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн Геронтологийн үндэсний төвд хийсэн хяналт, шалгалт хийсэн тайлангийн дагуу илэрсэн зөрчлийг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

| | |
|---|---|
| ДАРГА: | М.Энхбаяр (Дэд захирал), |
| НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: | Ч.Өнөрцэцэг(Хүний нөөцийн Менежер) |
| ГИШҮҮД: | Д.Янжмаа (Стратеги төлөвлөлтийн албаны даргын үүргийн түр хавсран гүйцэтгэгч, Ахлах нягтлан бодогч), |
| | Р.Даваадорж (Эрдэм шинжилгээ сургалтын албаны дарга, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга), |
| | А.Байгалмаа (Эмнэлгийн тусламж, үйлчилгээний албаны дарга), |
| | Д.Гунгаажав (Эдийн засагч), |
| | П.Байгальмаа (Нярав), |